

**Ойн нөхөрлөлүүдэд
мод үржүүлгийн талбай
байгуулж тарьц тарихад нь
зориулсан гарын авлага**

ded

Deutscher
Entwicklungsdienst



gtz

Ìàíäàë
Ñóìúí
Îéí Àíãè

Гарчиг

Хуудас

1.	Ойн газрын нөхөн сэргэлт	3
	1.1 Тарьц тарих хуулийн эрх зүй	3
	1.2 Тарьц суулгах арга хэмжээний төлөвлөлт	3
2.	Тарьц арчилах заавар	5
3.	Тарих арга барил	6
4.	Ойн үржүүлгийн газар байгуулах	7
	4.1 Ойн үржүүлгийн талбайг байгуулах үндэслэл	7
	4.2 Ойн үржүүлгийн талбайг байгуулах нөхцөл болзолууд	8
	4.3 Үржүүлгийн газрыг төлөвлөх	8
	4.4 Мод үржүүлгийн газар байгуулах	10
5.	Модны мөчрөөр тарьц бэлтгэх	13
6.	Үр бэлдэх	15
	6.1 Өөрсдийн үр гаргаж авах үндэслэл	15
	6.2 Үр гаргаж авах	15
	6.3 Үр боловсруулалт	19
7.	Ойгоо нөхөөгөө аргаар	21

1. Ойн газрын нөхөн сэргэлт

2007 оны Ойн тухай шинэ хуулинд монголын ойг ойн нөхөрлөлүүд, мод ба аж ахуйн үйлдвэр хувь хүмүүсийн оролцоотойгоор нөхөн сэргээхийг журам болгосон байгаа. Мод болон ойн бусад дагалдах баялгийг ашиглан хэрэглэж байгаа хүн бүр хуулийн дагуу ойд мод тарьж эргэн нөхөн сэргээх үүрэгтэй.

Ойг нөхөн сэргээх ажлыг хоёр замаар гүйцэтгэх боломжтой:

- Байгалийн сэргэн ургалтыг мал, гал мөн хүний үйл ажиллагаанаас хамгаалах.
- Модны суулгаж үр тарих.

1.1 Тарьц тарих хуулийн эрх зүй

Ойн шинэ хуулийн 27-р заалтанд юуны өмнө байгууллага болгон, хариуцаж буй ойн сандаа мод бэлтгэсэн буюу сүйтсэн талбайд нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулах үүрэгтэй. Энэхүү үйл ажиллагааг ихэнх хувийг нь ойн нөхөрлөлүүд өөрсдийн санхүүжилтээр, үлдсэн бага хувийг орон нутгийн буюу улсын төсвөөр санхүүжүүлэн хийнэ.

Ойн хуулийн 28-р заалтанд орон нутгийн байгууллага болон албан газаруудад хамаарах дараах зүйлүүд тусгагдсан байгаа. 16 нас хүрсэн Монгол иргэн болгон жилд хамгийн багдаа нэг мод тарих ёстой. Сум ба Багийн засаг дарга нар мод тарих арга хэмжээг өөрсдийн хариуцсан сум дүүргүүдэд зохион байгуулах хариуцлагыг хүлээнэ.

Ойг нөхөн сэргээх арга хэмжээнд ард иргэдийг хамруулсанаар ойн нөхөрлөлүүдийн хувьд сургалтанд хамрагдан хуримтлуулах туршлагаараа ойн менежмент дэхь үйл ажиллагааны талаар хангалттай мэдлэгийг олж авах боломж нээгдэж байгаа юм. Өөрсдийн мэдлэгээрээ ч тэр мөн тарьц худалдсанаар ч энэхүү хамтлагууд өөрсдийн сум дүүргийн ойн санг хадгалан нөхөн сэргээхэд үнэтэй хувь нэмрээ оруулах болно.

1.2 Тарьц суулгах арга хэмжээний төлөвлөлт

Янз бүрийн шалтгаанаас хамааран монголд ойжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь маш хэцүү болсон. Сүүлийн арван жилд Монголын ойн санг шинээр ойжуулан, түүнийгээ хадгалан үлдээх буюу ойн талбайг нэмэгдүүлэх тал дээр их хичээл зүтгэл гаргасан. Гэвч энэхүү ойжуулах үйл ажиллагааны маш цөөхөн нь үр дүнтэй байна. Олон зүйлүүд ойд хор хөнөөл учруулдаг. Жич: ойжуулсан талбайд ойн ба хээрийн түймэр,хаа сайгүй чөлөөтэй бэлчих малын сүрэг, мөн түүнчлэн зун нь халуун, өвөл нь их хүйтэн байдаг болон хатуу ширүүн уур амьсгал зэрэг.

Ойжуулах үйл ажиллагаанд хүч хөдөлмөр зардал их гардаг учир тарьц тарих арга хэмжээг эхлүүлэхээс өмнө зайлшгүй төлөвлөгөөгөө нягт нямбай гаргасан байх шаардлагатай. Зөвхөн ингэснээр тарилт амжилттай байх баталгаа болно. Тарих талбай болон тарих модны төрлийг зайлшгүй мэргэжлийн зөвлөгчийн хамт сонгоно. Түүнчлэн тарьц тарьсан ба хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа талаарх мэдээлэлийг тэр хавийн оршин суугч болон малчидад өгөх нь нэн чухал. Санамсаргүйгээр тус газрын ойр хавиаар бэлчих мал эсвэл өвс бэлдэх малчид ажлыг хэдэн өдрөөр саатуулж болно.

Анхааралдаа авах чухал зүйлүүд:

- тарих талбайг нягт нямбай сонгох
- тарьц тарих тохиромжтой хугацааг анхаарах
- гал болон малаас хамгаалах
- бүх хөрш малчидад мэдээллэх.

Тарих газрыг сонгох

Газраа сонгохдоо ойчин юм уу туршлагатай хүний зөвлөгөөг авах хэрэгтэй. Өнгөрсөн жилүүдийн туршлагаас үзэхэд ойжуулалтыг хашаажуулаагүй талбайд хийх нь үр дүнтэй байх нь ховор гэдгийг харуулж байна. Тарьц болон залуу моднуудыг том модны нөмөр бараадуулан эсвэл ойн жижиг цоорхойд тарих нь тэдэнд сайн ургах нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Ингэснээр том моднууд залуу мод тарьцнуудад зун хүчтэй нарны тусгалаас, өвөл хүйтнээс хамгаалалт болж өгдөг.

Ойн цоорхойн жижиг талбайг мөн өөр төрлийн буюу ховор модны төрлийг тарих зорилгоор ашиглаж болно. Үүнээс гадна ойд мод суулган ургуулж байгаа талбайг мал болон өвс бэлтгэдэг малчидаас хамгаалах нь илүү хялбар.

Тарих тохиромжтой хугацааг сонгох

Зарчимдаа бол тарилтыг хавар таван сард буюу намар арван сард хийдэг. Хавар тарьцуудыг ойн үржүүлгийн талбайгаас малтаж гарган авчиргаад үндэс нь ургаж эхлэхээс нь өмнө ойд тарьдаг. Намар бол тарьцны найлзуурыг моджисны дараагаар суулгадаг.


2. Тарьц арчилах заавар

Тарьц бэлдэх

Тарьцны үндэс нь маш эмзэг байдаг бөгөөд салхи нарны туяанд их хурдан хатдаг. Тийм учир тарьцнуудыг өглөө эрт буюу бүрхэг өдөр ойн үржилийн талбайгаас авах хэрэгтэй. Үүнээс гадна тарьцыг тухайн тарих өдөртөө л авна. Худалдаалах юм уу боож баглахынхаа өмнө тарьцуудыг нарийвлан үзэж чанарыг нь шалгана. Шалгуурт нийцэхгүй байгаа тарьцуудыг сортлон зарахгүй байх.

Чанарыг үнэлэх энгийн шалгуурууд:

- олон жижиг нарийн салаатай сайн ургасан үндэс
- үндэс найлзуурын харьцаа нь ойролцоогоор $1/3$ үндэс $2/3$ найлзуур байх ёстой.
- үндэс нь чийгтэй
- найлзуур нь сайн гарч ирсэн, навч шилмүүс нь ногоон
- тарьц ямар нэгэн өвчин буюу хортон шавьжинд идэгдсэн шинж тэмдэг байхгүй




Тарьцыг тээвэрлэх

Тээвэрлэхдээ тарьцыг нямбайлан боож нар салхинаас хамгаална. Хамгийн тохиромжтой нь бол гялгар уутанд хийж тээвэрлэх. Тарьцуудыг үндэсийг нь малтаж гаргасныхаа дараа чийгтэй шороотой цуг гялгар уутанд бооно. Ингэхдээ тарьцуудыг хоороонд нь хэт их дарж шахаж болохгүй бөгөөд тээвэрлэхдээ ил задгай ачааллах талбайд байрлуулан дээрээс нь нэмж чийгтэй хучлагаар бүтээж өгнө.

Тарьц хадгалан агуулах

Тарих талбай дээрээ ирэнгүүтээ сүүдэрт байх газарт гүнзгий нүх ухаж бэлдэнэ. Тарьцуудыг боодол боодлоор эгнээ болгон босоогоор нь нүхэнд хийгээд үндэсүүдийг нь нойтон шороогоор хучин шороогоо салхи оруулахгүйн тулд сайн чигжиж өгнө. Ингээд дараагийн эгнээ тарьцаа босоогоор нь давхарлан байрлуулж шороогоор сайн чигжиж өгнө. Ийм маягаар байрлуулсан тарьцуудыг өдрийн турш хадгалах боломжтой. Тухайн өдөртөө бүгдийг нь тарихгүй бол үлдсэн тарьцыг уг нүхэндээ үлдээнэ. Ингэхдээ үндэсийг хучсан шороог дахин нэг удаа норгож өгнө.



Анхаар: уг газар нь өдрийн турш сүүдэрт байх ёстой.

Ойн нөхөрлөлүүдэд мод үржүүлгийн талбай байгуулж тарьц тарихад нь зориулсан гарын авлага

3. Тарих арга барил

Ямар багаж хэрэгсэлийг ашиглахаас хамааран олон янзын тарих арга барилууд байдаг.

Гэвч ямар ч багаж хэрэглэж байсан ч үндсэн хэдэн зарчимуудыг анхааралдаа авна.

- . тарьцуудыг нар салхинд ил тавьж болохгүй. Тарихдаа тэднийг талбай руугаа аваачихдаа мөн л гялгар уутанд хийж зөөнө.
- тарих талбай зүлэг, навч, шилмүүс гэх мэтээр зүйлээр зузаан хучигдсан бол нүх гарган суулгахаасаа өмнө эхлээд тэднийг зайлуулна.
- нүхийг хар шороонд байхаар ухаж, үндэс нь уртаашаа бүхлээрээ багтахаар хэмжээний гүнзгий байна.
- үндэсийг нугалж хуйлсан буюу үзүүр нь дээш харсан байдалтай суулгаж болохгүй.
- тарьц үндэсийг болж өгвөл нүхэнд босоо шулуун байрлуулах
- суулгасан нүхээ эргээд шороогоор дүүргээд үндсэнд хөндий зай үлдээхгүйн тулд сайн дарж гишгэж өгнө.

4. Ойн үржүүлгийн газар байгуулах

Өнгөрсөн үед тарьцыг тарьж ургуулж байсан мод үржүүлгийн талбайнууд голцуу улсынх байсан. Ойн хууль шинээр гарч ашиглах эрхийг орон нутгийн ард иргэдэд олгосноор ойт хээрийн бүсэд амьдрах ард иргэд ойн санг нөхөн сэргээх хариуцлагыг үүний хамт бас хүлээх болсон. Ойн хууль нь байгууллагуудад ойг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйг олгодог.

Хэрэв ойн хуулийн дүрэм журам нь цаашид хэрэгжигдэхээр бол, Монголын бүх сум багуудад үр тариа болон тарьцны хэрэгцээ ихэснэ. Улс дангаараа цөөхөн хэдэн ойн үржүүлгийн талбайтай учир энэ хэрэгцээг хангах боломжгүй юм. Ийм болохоор хувь хүмүүс ба ойн нөхөрлөлүүдэд зохих сургалтанд хамрагдан, өөрсдийн туршлагаа хуримтлуулснаар хожим нь ойн сангаасаа үр тариа, үржүүлгийн талбайнаасаа тарьц худалдаалах боломжтой юм.

4.1 Ойн үржүүлгийн талбайг байгуулах үндэслэл

Ойн нөхөрлөлүүдэд өөрсдийн ойн үржүүлгийн талбайг байгуулах сайхан үндэслэлүүд байдаг ч үүний тулд тэд хэд хэдэн үндсэн нөхцөлүүдийг бүрдүүлэх хэрэгтэй. Мөн хэдийгээр Монголд байгалийн нөхцөл байдлууд орон нутаг болгонд өөр өөр байдаг ч бараг хаан ч усны эх үүсвэртэй, ямар нэг хэмжээгээр тэгш газар мөн сонирхол хүсэл эрмэлзэлтэй хүмүүсийг олж болно.

Өөрсдийн ойн үржлийн талбайг байгуулах давуу талууд:

- өөрсдийн үрээр ургуулсан тарьц нь тус газрынхаа нөхцөл байдалд дасан зохицсон байдаг ба илүү сайн ургах боломжтой
- тарьц худалдаж авахтай харьцуулбал илүү бага зардал
- төрөл бүрийн төрлийн тарьцыг өөрсдийн хүссэнээр ургуулах боломжтой
- тарихдаа удаан тээвэрлэхгүй учир тарьцны ургах чадвар нэмэгддэг
- цаг агаар нь тохирч байвал тарьцыг малтаж гаргах мөн тарих цаг заваа өөрсдөө төлөвлөнө
- бусад ойн үржлийн талбайн бүтээгдэхүүний санал болон нийлүүлэлтээс хараат бус байдал
- үр тарьц худалдсанаар ашиг орлогоо нэмэгдүүлэх



4.2 Ойн үржүүлгийн талбайг байгуулах нөхцөл болзолууд

Ойн үржлийн талбайг байгуулах тохиромжтой нөхцөлтэй газар тэр болгон хаа сайгүй байдаггүй. Ойн үржүүлгийн талбайг байгуулах газрын нөхцөл болзолууд:

- зуны цагт ширгэж хатдаггүй гол буюу худагнаас хангалттай ус авах боломж
- хөрс нь тэгш 1-2га газар, баруун зүгээс зүүн зүгрүү чиглэсэн
- мод бутны сүүдэр бараадуулж, ойн орчинг ашиглахын тулд ойд байвал сайн
- хүрч очиход хол биш ба байнга харж хянахын амрыг бодон үржүүлгийн газраа ахуйтай ойр сонгох
- малаас хамгаалан хашаа босгох

Үржүүлгийн газрыг байгуулахад маш бага зардал гарна. Зөвхөн хэдэн багаж хэрэгсэл болон материал л хэрэгтэй болно. Жич.:

- хүрз, хамуур, тармуур
- хувин юм уу цэцэг услах сав
- малаас хамгаалж хашаа босгох материал: өргөст тор юм уу банз
- мөчир, саваа мод, сүүдрэвч хийх материал
- тарих мод бургасны үр



4.3 Үржүүлгийн газрыг төлөвлөх

Ойн нөхөрлөлийн гишүүд ойн үржүүлгийн талбайг байгуулах саналд хүрвэл, юуны өмнө тэд нэлээд хэдэн зүйлүүдийг хоорондоо ярилцан тохиролцоод биелүүлсэн байх шаардлагтай. Нөхөрлөл үржүүлгийн газартаа зориулан бүх зүйлийг тусган оруулсан нэг менежмент төлөвлөгөөг боловсруулна. Энэ төлөвлөгөө нь үндсэн ойн менежмент төлөвлөгөөний нэг бүлэг байж болно.

Хамгийн чухал зүйл бол хэн нь ажлын үр дүнг хариуцах вэ гэдгээ шийдэх. Хамгийн тохиромжтой нь уг хүн нь үржүүлгийн газрын ойр амьдарвал зүгээр. Үүнийг харгалзан газраа сонгоно.

Зуны цагт үржүүлгийн газрын ажил болон түүнд тавих хараа хяналт ихсэнэ. Сонгогдсон өрх айл эсвэл хүн өөрийн үүргээ ихээр ухамсарлан гүйцэтгэнэ. Талбайг байнга хараа хяналтандаа байлган их цаг завьг түүнд зарцуулна.

Ойн нөхөрлөлүүдэд мод үржүүлгийн талбай байгуулж тарьц тарихад нь зориулсан гарын авлага

Төлөвлөх явцад ярилцан тогтоох ёстой гол зүйлүүд:

- хир их санхүүгийн хөрөнгө оруулалт шаардлагатайг?
- ямар материал багажнуудыг нэмж олж авах хэрэгтэйг?
- гишүүд ямар багаж, юугаар хувь нэмрээ оруулах боломжтойг?
- хэрэгцээт зүйлийнхээ зарлаг зардалыг яаж зохицуулхаа?
- нөхөрлөл хаан хэнээс мэргэжлийн зөвлөлгөө, дэмжлэг туслалцаа авах боломжтойг?
- үржүүлгийн газар хир том байх ёстойг?
- ямар төрлийн хэдэн тарьц ургуулах гэж байгааг?
- үр тариагаа хаанас авах аа?
- хэдэн тарьц тарихаа, хэдэн тарьц зарах боломжтойг?
- үржүүлгийн газрыг хэнд хариуцуулан өгөхөө, хэн нь ажилчдын оролцоог зохицуулахыг, хэн нь тогтмол харж хянахыг?

Ганц хүн буюу өрх айлд ноогдох ажлын ачаалал маш их байна. Ажил эхлэхээс өмнө гишүүдийн ажлын болон цаг заваа хэрхэн зарцуулах хувиарыг гаргаж өгөх ёстой. Үүнд хэн хэзээ хаан ямар ажлыг хийхийг тогтоогоод бичгээр боловсруулах нь зүйтэй.

Мөн түүнчлэн санхүүгийн хэрэгцээ болон төсвийн төлөвлөгөөгөө тодорхой гаргана. Зардал баланс болон ажлын зарцуулалтыг цаг тухайд нь хөтөлсөнөөр улирлын эцэст ашиг алдагдалаа зөв тооцон гаргана. Мөн үр тариа буюу тарьц борлуулж олсон ашиг орлогоо яаж хувиарлахаа урьдаас шийдсэн байна. Иймэрхүү асуудлыг ашиг орлогоо олж эхлээд байхдаа ярилцахгүй.

Ерөнхийдөө эхлээд өөрсдийн хэрэгцээнд зориулан нэг бага хэмжээний үржүүлгийн талбайнаас эхлэх нь зүйтэй. Үржүүлгийн газрыг эрхлэх туршлага байхгүй бол үүнд их хэмжээний хөрөнгө зарцуулаад хэрэггүй. Эхлээд нөхөрлөлд хир их цаг зав шаардлагатай байдгийг, сонгосон газар нь тохирч байгаа эсэхийг мөн гишүүд төлөвлөж байснаар ажилд оролцож байгаа үгүйг нэг туршаад үзэх хэрэгтэй. Хэрэв ажил амжилттай урагшилж тарьц худалдах боломжтой болвол, талбайг дуртай үедээ өргөжүүлэн тэлж болно.

4.4 Мод үржүүлгийн газар байгуулах

Талбайг бэлтгэх

Наанги шороо элс холилдсон хөрс нь хамгийн тохиромжтой байдаг. Газар нь болж өгвөл тэгшхэн байх хэрэгтэй ба намар нь түүнийг 30см хүртэл гүнзгий хагалаад хог ургамал, үндэс чулуунуудыг зайлуулна. Ухаж гаргасан шороогоо үлдээснээр цас бороо ороход чийг хөрс рүү хялбар нэвтрэх боломжтой байдаг. Хавар нь үнс ба үхрийн бууцыг бордоо болгон хөрсийг борнойдохоос өмнө асгаж өгнө.

Тарьцыг хайрцаглаж тарих талбайг бэлдэх

Хэдэн тарьц ургуулахаа шийдсэний дараа хайрцгийнхаа тоог гаргана. Хайрцагны тоо хэмжээ нь тарьцны тооноос хамаарна.


Анхаар:

Нарс ба шинэсийн үрийг маш шигүү тарьдаг. Нэг 5 м² хэмжээтэй хайрцаганд ойролцоогоор 1000 тарьц ургуулах боломжтой. Жимс жимсгэний модыг ургуулахад арай илүү зай шаардлагатай.

Нэг хайрцаг 0,8-1метрээс илүүгүй байх хэрэгтэй, тэгвэл түүнийг 2 талаас нь эдэлж ажиллахад хялбар байдаг. Хайрцгийн урт нь тухайн газар болон ямар төрлийн хэдэн тарьц ургуулахаас хамаарна. Хайрцгүүдийг баруунаас зүүн зүгт байрлуулах нь хамгийн тохиромжтой. Ингэвэл ургаж байгаа тарьцнууд нарны туяаг бүгд адил авна. Мод бут болгоны төрөлд тус тусад нь тарих хайрцаг бэлднэ.

Хайрцаг болгоныг шороогоор тойруулан далан босгоно. Ингэвэл усалгааны үеэр ус хайгцагнаас урсахгүй дотор нь тогтоно. Бүх тарьцнуудыг бүгдийг нь адил усаар хангаж өгөхийн тулд хайрцаг болгоны хөрсийг сайн тэгшилж өгнө.

Мал оруулахгүйн тулд хайрцагнуудаа тойруулан зайлшгүй хашаа босгоно. Нэг ямаа гэхэд л хэдхэн хормын дотор маш олон тарьц идэж үгүй болгох чадвартай. Хэрэв тус газар туулай ихтэй бол хашааны доод талыг илүү их нягт ойр зайнд хийж өгнө.




Сүүдрэвч

Үржүүлгийн газраа том мод бутны сүүдэрт байрлуулах нь хамгийн тохиромжтой. Үгүй бол зуны саруудад тарьц цухуйж эхлэнгүүт хайрцаг дээгүүр нь сүүдрэвч байрлуулна.

Үүний тулд талбайг тойруулан модны мөчирөөр хийсэн рамыг босгоно. Энэ рам дээрээ мөчир, тор эсвэл сүүдрэвч хийх материалаар хучин бэхэлнэ.

Тарьцуудыг нарны туяанаас бүхэлд нь хаахаар биш харин зөвхөн нарны туяаг сааруулах гэж сүүдрэвч тавьдаг.

Найман сарын сүүлд халууны эрч буурсаны дараа сүүдрэвчээ авна.



Хараа хяналт

Үржүүлгийн талбайг байнга хараа хяналтандаа байлгана: мал оруулж болохгүй, усны хэрэгцээ ба хортон шавьжинд идэгдээгүй эсэхийг тогтоохын тулд ургамалыг үргэлж шалгаж байх. Хэрэв хариуцагч хүн нь талбайн хажууд амьдарвал хараа хяналт сайн тавих болно.

Өвлийн арчилгаа

Өвөл тарьцнуудыг их хүйтнээс хамгаална. Хүйтний эрч чангарах хүртэл хайрцаганд тарьсан тарьцаа усалсаар байна. Өвлийн цагт ялангуяа шинэс болон нарсыг хучхад бургас мөн бусад бутны мөчрүүд хэрэгтэй. Мөчрүүдийг нэг раман дээр тавьж газраас 20-30см өндөрт байрлуулан тогтооно. Ямар ч тохиолдолд модны үртсийг үүнд хэрэглэхгүй.

Заавар:

Хэрэв үржүүлгийн газар болон ганц хоёр хайрцагаа тарьцанд ашиглахгүй бол тэдгээрт хогийн ургамал ургуулахгүйгээр ногоо тарьж ашиглаж болно.

Ойн нөхөрлөлүүдэд мод үржүүлгийн талбай байгуулж тарьц тарихад нь зориулсан гарын авлага

Үр тарих

Үр тарих зөв цаг хугацаа нь газар болгонд өөр өөр байдаг. Ер нь бол хүйтний элч суларсан 5 сард тарьдаг. Талбайг эхлээд сайн усална. Хайрцаг дотроо нэг урт саваа модоор үрнүүдээ байрлуулах зурааснуудыг 1-2 см гүн хоорондоо 15-20 см зайтай татан ховил гаргана. Үрүүдийг гаргасан ховилд хийн хөрсөөр хучаад гишгэхгүйгээр зөвхөн зөөлхөн дарна.

Усалгаа ба хөрс боловсруулалт

Бороо хангалттай орохгүй байгаа үед тарьцыг тогтмол услах шаардлагтай. Хөрсийг хатаж байгаа үгүйг байнга шалгаж байх хэрэгтэй. Нарны хурц туяа салхи хоёр хөрсийг хурдан хатааж чийггүй болгодог.

Усалгааг өглөө эрт юм уу орой үдэш хийдэг. Усаа өмнө нь хувин саванд хийн наранд тавьж бүлээн болгосон байна.

Хог ургамалыг цухуйгаад ирвэл устгана. Өөр ургамалуудаар тарьцнуудыг бүрхэн ургуулж болохгүй.

Тогтмол усалгаа хийснээр хөрс хурдан нягтран хатуурдаг. Тэгвэл эгнээ хоорондох хөрсийг нэгэн жижиг тармуураар сийрүүлж өгнө. Тарьцнууд ургаад том болох үед хөрсмйг сийрүүлж байхдаа үндсийг нь тармуураар гэмтээхгүй байхад анхаарах хэрэгтэй.

Тарьцнууд хэт шигүү цухуйвал, нягтралыг нь багасгаж өгнө. Үүний тулд тарьцнуудыг хавар тарьсаны дараагаар хөрсөө сайн чийгэлж байгаад арай бүдүүн тарьцнуудыг болгоомжтойгоор сугалан аваад хэдхэн см зайнд эргүүлэн хайрцагандaa суулгана.


5. Модны мөчрөөр тарьц бэлтгэх

Зарим төрлийн мод бутыг мөчрөөр нь тарихад илүү хялбар байдаг. Модноос мөчрийг нь тайрч аваад хөрсөнд тарьц шиг суулган үндэслүүлэн ургуулж болно. Мөчир бэлдэхэд хэцүү биш ч гэсэн нямбай ажлыг шаардна.

Мөчрөөр тарьж болох модны төрлүүд:

Чацаргана, үхрийн нүд, бургас, улиас

1. Эхний алхам- таарч тохирох мөчиртэй үрийн модыг олно. Зөвхөн доод тал нь 20см урттай эрүүл мөчрийг ашиглаж болно. Нэг мөчир нь хамгийн багадаа 3 нахиатай байх ёстой. Зураг 1. Мөчрийг өвөл моджоод нахиа нь дараа жилд нахиалахад бэлэн болчихсон байхад нь тайрна.
2. Тайрахдаа мөчрийг огтолж байгаа газраар нь цавтуулахгүйн тулд маш хурц хутга хэрэглэнэ. Дээд доод хоёр талыг ялгахын тулд өөр өөрөөр тайрч авна. Дээд талыг нь ойролцоогоор 45градус ташуу, доод талыг нь 90градус тэгш тайрна. Зураг 2.
3. Өвөл тайрч авсан мөчрүүдээ маш сайн булдаж хадгална. Хамгийн тохиромжтой нь тэднийг нэг шуудуунд нягт хийгээд шороогоор булдаж хадгална. Ингэхдээ завсар хооронд нь агаар үлдээж болохгүй эс тэгвэл агаараар дамжин мөчир хөлдөнө. Зураг 3.



Ойн нөхөрлөлүүдэд мод үржүүлгийн талбай байгуулж тарьц тарихад нь зориулсан гарын авлага

4. Хавар мөчрүүдийг тарьц шиг суулгаж болно. Зураг 4. Мөчрийг доод талаар нь $1\frac{1}{3}$ хүртэл нь гүнзгий хөрсөнд суулгана. Дараа нь хөрсийг сайн чигжиж өгнө. Ингэснээр мөчрүүд усалгааны үеээр унахгүй. Шороог чийг сайтай байлгана.

Мөчрүүдийг эхлээд ихэнхдээ мод үржүүлгийн газарт тарьдаг. Тэнд тэдний үндэсийг нь ургуулах гэж 1-2 жил байлгадаг ба малаас хамгаалан бусад ургамалын адил усжуулна.

6. Үр бэлдэх

Үрийг мод үржүүлгийн газар, худалдаачин эсвэл байгаль орчны байгууллага зэргээс олж авч болно. Мөн өөрсдөө мод бутны төрлөөс үр авч болно. Өөрийн ойгоос үр авч бэлдэх нь хэдийгээр хэцүү биш ч сонголт хийхдээ зарим нэг зүйлүүдийг анхаарах хэрэгтэй: хамгийн тохиромжтой арга, хадгалалт ба эмзэг үрийг арчилах зэрэг.

6.1 Өөрсдийн үр гаргаж авах үндэслэл

Монголын өөр газар нутаг юм уу гадаадаас үр худалдаж авахад үрнээс ургах мод нь тус газрын уур амьсгал болон нөхцөл байдалд нь дасан зохицон ургахгүй байх талтай. Үүнээс гадна үрийн модны чанарыг мэдэх боломжгүй байдаг. Ядаж өөрсдийн газраас байгалиараа ургаж байгаа модноос үр авах нь харьцангуй хялбараар юм.

Монголын орон нутгуудад ойн нөхөрлөлүүд өргөжин хөгжиж байгаа болохоор цаашид тэд хоорондоо үр тариа, тарьц мөн туршлага солилцож болох нэгэн сүлжээ үүсэн бий болно. Ийм замаар өөрт байхгүй мод бутны төрлийг олж авах нь хялбар болно. Жич.: жимсний бут

Өөрсдийн үр гаргаж авах давуу талууд:

- өөрсдийн үрээр ургуулсан тарьц нь тус газрын уур амьсгал нөхцөл байдалд дасан зохицсон байдаг
- үнэтэй үр авах зардал гаргахгүй
- бусад мод үржүүлгийн газруудын бүтээгдэхүүний нийлүүлэлтээс хараат бус байна
- үр ба тарьц худалдсанаар ашиг орлого боломж

6.2 Үр гаргаж авах

Үрийн модыг сонгох

Эхний алхам нь тарих мод бутны төрлийг, дараа нь үр авах үрийн модоо сонгоно. Үрийн модоо маш нарийн сонгох ёстой, учир нь үр нь үрийн модны шинж чанарыг өвөлж авдаг.

Сайн үрийн мод нь:

- эрүүл, өвчин буюу хортон шавьжинд идэгдээгүй
- хэдэн жилийн өмнөөс тогтмол үр боловсруулж байгаа
- ургац авах жилд хангалттай үр, боргоцой өгсөн.

Үр авах модыг сонгоход нэг хялбар арга байдаг:
Үр авсан үрийн модны шинж чанар үрнээс ургах модонд хожим нь илэрнэ.

Үр авах тохиромжтой хугацаа

Нарс ба шинэсийн үрийг намар боловсорсных нь дараа гэхдээ мод боргоцойноосоо унаагүй байх үед нь авдаг. Нарсны үр боргоцойндоо дөнгөж 2дахь жилээс л боловсорч эхэлдэг ба дараа жилийн хавар боловсорч гүйцдэг. Боргоцойг боловсорсон үгүйг далавчнуудын байрлалаар мэдэж болно. Нарс болон шинэсийн үрнүүд тус тусдаа далавчин доор байдаг. Далавч нь хаалттай байгаа боргоцойг түүж авдаг. Далавч нь бараан хүрэн өнгөтэй болсон боргоцойг онгойлгоход хялбар байдаг ба үр нь өөрөө ундаг. Үр нь ихэнхдээ бараан хүрэн юм уу улаан байдаг. Боловсорсон үр нь том байдаг.

Модны төрлөөс үр авах цагийн хүснэгт:

Шинэс	Нарс	Хуш	Хайлаас
<ul style="list-style-type: none">• 10-р сараас үр нь боловсордог, ү• рийг авахад боргоцой нь үүрдэг• 1кг үрнээс ойролцоо 35.000 тарьц	<ul style="list-style-type: none">• 2 дахь жилийн өвлөөс боловсордог,• далавчнууд нь өөрсдөө нээгддэг• 1кг үрнээс ойролцоо 50.000 тарьц	<ul style="list-style-type: none">• үр нь хавар эрт боловсордог	<ul style="list-style-type: none">• үр нь 5 юм уу 6-аар сарын сүүлээр боловсордог,• үрийг модноос унахад нь модны доор тор дэвсэж авна• шууд тарина

Үр авах арга

Үрийг авахын тулд модыг их бага хэмжээгээр гэмтээж байгаад авах янз бүрийн аргууд байдаг:

- өөрөө унасан эсвэл модыг сэгсэрч үрийг унагаасны дараагаар үрийг газраас түүх
- унасан модноос –гэхдээ үр авах гэж унгаагаагүй шүү- үрийг нь түүж авах
- үр байгаа мөчрийг тайрч авах
- олсоор мөчрийг доош нь татаж авах
- модонд авирах.

Үрийг өөрөө унасны дараа түүх

Энэ арга том жимс юм уу үртэй мод бутнуудад илүү тохиромжтой. Унасан үрийг газраас өдөр болгон шинээр түүж авна. Учир нь үр жимс нь газар дээр унаад удалгүй шавьж хөгзөнд хурдан идэгддэг. Энэ арга нь шинэс нарс модонд тохиромжгүй юм яагаад гэвэл энэ моднуудын үр нь эхлээд унаж боргоцой нь дөнгөж нэг жилийн дараа л модноос ундаг.

Ажиллага


- р жимсийг унахаас нь өмнө, түүхэд хялбар болгон модны доорх газрыг тармуураар цэвэрлэж алчуур юм уу бэрзээнт дэвсэж болно
- үр жимсийг мөчир дээр унах гээд сулраад ирэнгүүт мод мөчрийг нь сэгсэрэн унагааж болно
- хамуураар үр жимсийг бэрзээнтэн дээрээ бөөгнүүлэн аваад дараа нь хогноос нь цэвэрлэнэ

Мөчрийг нь тайрч авах

Энэ аргыг үрийг өөр аргаар авах боломжгүй үед л хэрэглэнэ. Урт хайч эсвэл хөрөөгөөр мөчрийг тайрч унгаана. Тайрахдаа модны холтосыг нь зулгааж авбал модыг гэмтээж болох тул хөрөө хайч нь маш хурц байх шаардлагатай.

Ажиллага

- хөрөөгөө нэг урт саваа модны үзүүрт маш сайн бэхэлж тогтооно. Зургийг хар.
- тайрах гэж байгаа мөчир нь бөөн олон үртэй байхын хажуугаар түүнд хүрэхэд хялбар байх хэрэгтэй. Модны өөр салаа мөчирт тээглэхээргүй байх, тэгэхгүй бол огтолсны дараа доошоо унахгүй тээглэн үлдэж болно.
- модны доорх газрыг цэвэрлэж бэрзээнт\ алчуур дэвснэ. Дэвссэн бэрзээнт дээр хөрөөдөж байх явцад доош унах үрнүүдийг цуглуулан авна.
- мөчрөө унгаагаад үр жимсээ түүж авна.



Олсоор мөчрийг доош татаж үр авах

Энэ аргыг мөн адил өөрөөр үр авах боломжгүй тохиолдолд хэрэглэнэ. Мөчрийг олсоор татах үед мөчир хугарч болзошгүй бөгөөд ингэвэл модыг гэмтээнэ. Тийм учир үүнд мөчрийг хугалж гэмтээхгүйгээр доош нь татхад мэдрэмж эв дүй хэрэгтэй.

Ажиллага

- нэг урт олсны нэг үзүүрт нь тухай болгон элстэй жижиг уут юм уу чулуу бэхэлнэ
- сонгосон мөчир нь бөөн олон үртэй ба салаа мөчрийн захад байвал зүгээр
- олсоо нэг үзүүрээс нь барин туухайтай үзүүрийг мөчир давуулан шидээд доош нь татна

Модруу авирах

Модруу авирахад бас л ур чадвар хэрэгтэй. Үрнүүд ихэнхдээ модны ишний ойр биш харин салаа мөчрүүдийн захын мөчирт ургадаг. Тийм учир тийш авирч гарах нь аюулгүй зүйл биш юм. Авирч байгаа хүн хурц хөрөө мөн үрээ хийх дүүжилдэг ууттай байх хэрэгтэй. Салаа мөчрийн захын мөчрүүдэд хүрэх боломжгүй бол хөрөөдөн унагааж үрийг нь авна.

6.3 Үр боловсруулалт

Үр гаргаж авах ба хатаах

Үр жимснүүдээ цуглуулсаны дараа тэднээс үрээ гаргаж авна. Үрийг байгалийн жамаар намар тарьж болох авч, үрийг хаврын эхэнд тарих нь илүү. Яагаад гэвэл хавар таривал шавьж хөгцөнд идэгдэх нь бага байдаг. Өвөлийн турш хадгалахад үрийг маш сайн бэлдсэн байх хэрэгтэй.

Ажиллага

1. Боргоцойнуудыг бэрзээнт юм уу алчуур дээр тараагаад наранд тавина. Эсвэл боргоцойнуудыг даавуун уутанд хийгээд гэрт зуухны дээр өлгөж сул галны дөлд хатааж болно.
2. Үрнүүдийг ингэхдээ байнга нөгөө талаар нь эргүүлэн тавина эсвэл уутыг сайтаар сэгсэрч өгнө.
3. Үрийг гадаа хатааж байгаа тохиолдолд шувуу болон мэрэгч амьтдаас хамгаална.
4. Ойролцоогоор 2-4 хоног хатаана.
5. Боргоцойг хатангуут далавчнууд нь нээгддэг.
6. Боргоцойнуудыг уут\ шуудайнд хийж амыг нь боогоод үрийг нь гаргахын тулд сайн сэгсэрч дээрээс нь дарна.
7. Няцлагдсан боргоцойнуудаас үрийг түүж авна.

Үр хадгалах

Үрийг хамгийн ихдээ хагас жил л хадгалдаг. Шилмүүст модны үрийг зөв хадгалвал соёолох чадвар нь хэдэн жилээр хадгалан үлддэг. Үрийн соёолох чадварыг хадгалахын тулд хадгалахдаа зарим нэг зүйлүүдийг зайлшгүй анхаарах хэрэгтэй.

Ажиллага

1. Хадгалалтанд тагтай агаар орохгүй битүү сав хэрэглэгдэнэ. Жич.: тагтай шил
2. Шилэн дотор үртэй хамт чийг уудаг материалыг хийж болно. Жич.: сонингийн цаас, үнс
3. Шил сав дээр үрийн төрөл, он сар, түүж авсан газрыг тэмдэглэн наана.
4. Саваа сэрүүн хуурай газар хадгална.
5. Хоёр долоо хоногт нэг удаа үртэй саваа онгойлгон чийг даан хөгцөрж байгаа эсэхийг шалгана.

Үрийн соёололтыг шалгаж үзэх ба тарих

Хавар ургалтын улирал эхлэхэд үрээ мод үржүүлгийн талбайдаа тарина. Тарихаас өмнө үрийн соёолох чадварыг мэдэх мөн соёололтыг хурдасгах арга.

Ажиллага

1. Үрнүүдийг бүлээн устай саванд хийгээд дэвтээнэ.
2. Гүйцэд боловсорсон эрүүл үр нь хүнд байдаг учир доош тунана.
3. Хоосон гүйцэд боловсроогүй үр усан дээр хөвж үлдэнэ. Ийм үр соёолох чадваргүй бөгөөд хэрэглэгдэхгүй.
4. Усанд тунаж үлдсэн боловсорсон үрийг тарилтанд хэрэглэнэ.
5. Үрнүүд усанд хөөж томорно.
6. Үрнүүдийг усан дотор байлгаж байгаад тэр чигээр нь хайрцаг дотор тарина.

Үрийг шалгаж үзэх заавар

Үрийн соёолох чадварыг хувиар тогтоохын тулд үрийг соёолуулж үзнэ. Ялангуяа үрнүүдээ сүүлд нь худалдаалах гэж байгаа бол заавал соёолуулж үзэх шаардлагатай.

Ингэхийн тулд үрнүүдээ нойтон хөвөн дээр ташуу 10 хөндлөн 10 эгнээтэй нийт нэг хөвөн дээр 100 ширхэг үр байхаар байрлуулна. Ингэж бэлдсэн хамгийн багдаа 5 үртэй хөвөн бэлдээд хэдэн өдөр байлгана. Хэд хонгийн дараа соёолсон үрнүүдийг тоолно. Бүх хөвөн дээрх соёолсон үрнүүдийн тоог хооронд нь нэмээд байгаа хөвөнгийнхөө тоонд хуваахаар үрийн дундаж соёолох чадвар гарч ирнэ.


Жич.: хөвөн болгоны дээр 100 үр байрлуулсан 5 хөвөн бэлдлээ. Эхний хөвөн дээр 100 ширхэг үрнээс 65, хоёр дахь дээр 74, гурав дахь дээр 81, дөрөв дэхь дээр 72, тав дахь дээр 83 нь соёолсон бол энэ тоонуудаа хооронд нь нэмээд 375 болно. Энэ тоогоо 5д хуваах юм бол 75 гарна. 75 бол үр соёолох чадварын дундаж хувь нь юм. Ийм маягаар шалгаж үзнэ:

$$\begin{array}{ccccccccc} 65 & + & 74 & + & 81 & + & 72 & + & 83 & = & 375 & : & 5 & = & \underline{75\%} \\ \textcircled{65} & & \textcircled{74} & & \textcircled{81} & & \textcircled{72} & & \textcircled{83} & & & & & & & \end{array}$$

7. Өвөөлжин царилна



Нарсны 2-3 настай суулгац материалыг ойд тарихдаа өвөөлжин царил, колесовын царил, хожуул өрөмдөж үр суулгах зэрэг аргуудаар ойжуулалт хийнэ.

Өвөөлжин царилаар өнцөглөн тарих арга.



Өвөөлжин царилаар 1-2 ойжуулагч ажиллана. Тарихдаа нэгдэх ойжуулагч зүүн хөлөө урагш, баруун хөлөө алхамын ард байрлуулж царилын сүхтэй талаар хөрсийг эгц хагалж өгөөд царилын ишнээс 90°-аар дээш нь түлхэн өгч царилаа сугалж авна.

Царилаа сугалж авсаны дараа царилны гапуутай талаар нь далайн сүхээр цавчиж гаргасан эгц хананд тэгш өнцөгөөр цавчиж өгнө.



Царилныхаа ишийг дээш өргөж өгөнгүүтээ баруун гар талруугаа дарж хөрсийг өнцөглөн хуулж өндийлгөж өгнө. Ингэж өндийлгөж өгсөн үед 2-р ойжуулагч тарьцаа баруун гар талаараа үндэсний хүзүүвчээр барьж сүхээр цавчсан эгц хананд хийж өгнө.

Тарьцыг суулгамагц ойжуулагч царилаа баруун хөлийн өвдгөн дээрээ дарж өгч сугалж аваад зүүн хөлөөрөө тарьц суулгасан хөрсөн дээр гишгэж өгч хөрсийг нягтруулж өгөөд дахин царилны сүхтэй талаар нь цавьчиж өгөх г.м-ээр тарина.



Колесовын царилаар тарих арга

Тарьц суулгацыг Колесовын царилаар суулгахад эхний хүн царилаараа нүх гаргаж өгөхөд хоёрдогч хүн тарьцаа нүхэнд нь үндэсний хүзүүвч хүртэл суулгаж өгөхөд II хүн араас нь 2 удаа шахалт хийж өгч амсрыг гишгэж битүүлж өгнө.